



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА УВС АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын газраас 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийсэн нийцлийн аудитын тайлан.



**Зарим байгууллагууд батлагдсан төсвийг зориулалт
бусаар зарцуулсан байна.**

Увс аймгийн Цагаанхайрхан сумын төсөвт байгууллагуудын
2014, 2015 оны санхүүгийн үйл ажиллагааны үр дүн

2016 оны 10 сар

УВААГ-2016/08-НА

УВААГ-2016/08-НА

Тайлан бэлтгэсэн:	Агуулга	3
Дарга, тэргүүлэх аудитор Б.Авирмэд	Товчилсон үгийн тайлал	4
Аудитын менежер Ж.Энхжаргал	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	5
Ахлах шинжээч М.Батсуурь	Бүлэг 1. Зарим байгууллагууд батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.	7
Шинжээч Я.Зунгарав	Бүлэг 2. Үндсэн хөрөнгө, бараа материалын ашиглалт, хадгалалт хэвийн, тендер зарлахгүйгээр шууд худалдан авалт хийжээ.	11
2016 оны 10-11 дүгээр сар	Бүлэг 3. Дотоод хяналтын тогтолцоо бүрдсэн ч зарим байгууллагын өмч хамгаалах зөвлөл хангалтгүй ажилласан байна.	13
	Дүгнэлт	15
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7045-3317, 7045-3721, 70453799, 7045-4721 дугаарын утсаар харилцана уу.	Зөвлөмж	16
Хаяг: Увс аймгийн Аудитын газар Улаангом сум 3 дугаар баг аймгийн Засаг даргын тамгын газрын байр		

Товчилсон үгийн тайлал:

ИТХурал	- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГазар	- Засаг даргын тамгын газар
ЭМТөв	- Эрүүл мэндийн төв
ХХОАТ	- Хувь хүний орлогын албан татварын
ХХК	- Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу, Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цагаанхайрхан сумын төсвийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааны үр дүнд нийцлийн аудит хийлээ.

Аудитын зорилт

Энэхүү аудитын зорилт нь Цагаанхайрхан сумын төсөвт байгууллагууд төсөв санхүүжилт болон хөрөнгө нөөцөө үр ашигтай, үр дүнтэй, хууль тогтоомжийн хүрээнд зарцуулж байгаа эсэх, өмнөх аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд хэрэгжсэн эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, үр нөлөөг дээшлүүлэх талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд санал зөвлөмж боловсруулж хүргүүлэхэд чиглэгдэнэ.

Энэ зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх.
- Үндсэн хөрөнгө, бараа материалын ашиглалт, хадгалалт үр дүнтэй байгаа эсэх
- Дотоод хяналт, хариуцлагын үр нөлөөтэй тогтолцоо бүрдсэн эсэх

Хамарсан хүрээ

Аудитыг Цагаанхайрхан сумын төсөвт байгууллагын 2014, 2015 он, Эмийн эргэлтийн сангийн 2014-2016 оны санхүүгийн үйл ажиллагааг хамруулан хийж гүйцэтгэв.

Арга зүй

Аудитыг АДБОУС 100-400, 4200, Төрийн хяналт шалгалтын стандартыг баримтлан холбогдох албан тушаалтантай ярилцах, судалгаа авч дүн шинжилгээ хийх, санхүүгийн тайлан, хөрөнгийн бүртгэл, анхан шатны баримт, ажлын төлөвлөгөө, тайлантай тулган баталгаажуулах, үндсэн хөрөнгөд биет тооллого хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Энэхүү нийцлийн аудитыг явуулахад Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журам, Үндэсний аудитын газрын харъяа Увс аймгийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторын баталсан Нийцлийн аудитын төлөвлөгөөг мөрдөж ажиллалаа.

Нийцлийн аудитыг ахлах шинжээч М.Батсуурь, шинжээч Я.Зунгарав нар 2016 оны 10 сарын 20-ноос 28-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл:

Хантайшир уулын аймгийн Ханхөхий уулсын хошуунаас 1931 онд тасарч Увс аймагт харьяалагдаж Туруун сум Мөндөөхөөд төвлөрсөн. 1959 онд БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчдийн зарлигаар Туруун сумыг 2 хувааж Цагаанхайрхан сум болжээ

Улаанбаатар хотоос 1350 км, аймгийн төвөөс 235 км хол зайд оршдог, Баруунтуруун, Өндөрхангай, Завхан, Хяргас, Зүүнговь, Завхан аймгийн Ургамал сумтай хиллэдэг.

Ханхөхийн нурууны ар өврийг дамнасан хангай, говь, ойт хээр хосолсон 399.4 мянган га нутаг дэвсгэртэй, сумын газар нутаг нь далайн түвшнээс дээш 2511 метр өргөгдсөн, Хулж, Хунт, Арбулаг, Мөндөөхөө гэсэн 4 баг, 554 өрх, 1988 хүн амтай, 141810 толгой малтайгаас 312 тэмээ, 4511 адуу, 4051 үхэр, 64061 хонь, 68875 ямаа байна. Сумын хэмжээнд 412.8 га хадлангийн талбай, 33.1 га газар тариалан эрхэлдэг.

ИТХ, ЗДТГазар, Дунд сургууль, Хүн эмнэлэг, Эрүүл мэндийн төв, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, ШТС, ХААН, Төрийн банк, мал эмнэлэг, худалдаа, нийтийн хоолны үйлчилгээний болон Модон эдлэл, сүү, сүүн бүтээгдэхүүн зэрэг жижиг дунд үйлдвэрэлийн чиглэлээр аж ахуйн нэгж байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна.

Нийцлийн аудитын хамрах хүрээнд ИТХ-ын даргаар Д.Эрдэнэ-Очир, Засаг даргаар Г.Энхбат, ЗДТГ-ын даргаар С.Цэцэгмаа, Дунд сургуулийн захирлаар Д.Цэрэннадмид, Эрүүл мэндийн төвийн эрхлэгчээр Н.Энхтуяа, Д.Бурмаа, Л.Солонго, Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгчээр Н.Нарангэрэл, Соёлын төвийн эрхлэгчээр Х.Амгалан, Төрийн сангийн төлөөлөгчөөр А.Байгалмаа, ИТХ, ЗДТГ, Багийн нягтлан бодогчоор Б.Эрдэнэбилэг, Дунд сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төвийн нягтлан бодогчоор Б.Лхамсүрэн, Эрүүл мэндийн төв, Эмийн эргэлтийн сангийн нягтлан бодогчоор Г.Алтанчимэг, Эмийн эргэлтийн сангийн эрхлэгчээр Ж.Аюуш нар тус тус ажиллажээ. Эмийн эргэлтийн сан нь ХААН банкинд харилцах данстай сумын Засаг дарга 1-р гарын үсгийг, сумын Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч 2-р гарын үсгийг зурж захиран зарцуулсан байна.

Цагаанхайрхан суманд нийцлийн аудит хийх явцад төсвийн байгууллагууд болон Эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагаатай холбоотой иргэдийн санал хүсэлтийг хүлээн авахаар зарлал байрлуулж ажиллалаа.

Бүлэг: 1

Зарим байгууллагууд батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

1.1. Зарим хууль, эрх зүйн заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Цагаанхайрхан сумын төсөвт байгууллагууд нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль, эрх зүйн актын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Цагаанхайрхан сумын төсөвт байгууллагууд батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байгаа ч зарим хууль эрхзүйн актуудыг зөрчжээ.

Цагаанхайрхан сумын Засаг дарга МЗХ-ны “Тэргүүний залуу алтан медаль” шагналаар шагнагдсаны дагалдах шагнал нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг ЗДТГ-ын даргын 2015 оны А/30 тоот тушаалаар олгосон байна.

Энэ нь Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 26.3-д “Энэ хуулийн 26.2-т зааснаар нэр дэвшүүлсэн бол ... сум, дүүргийн Засаг даргыг аймаг, нийслэлийн Засаг дарга, ... 4 жилийн хугацаагаар томилно”, 26.8-д “Сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга тухайн Хурлын болон дээд шатны Засаг даргын өмнө ажлаа хариуцна.”, Төсвийн тухай хуулийн 40.4-д “Үр дүнгийн гэрээний биелэлт, хэрэгжилтийн явц байдалд үндэслэн үр дүнгийн гэрээг дүгнэх эрх бүхий этгээд нь дараах арга хэмжээг авна”, 40.4.2-д “хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд урамшуулах, хариуцлага тооцох.” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”, 70.5-д “Зөрчлийн хэлбэр, хүлээлгэх хариуцлагаас үл хамааран энэ хуулийг зөрчсөний улмаас төрд хохирол учруулсан буруутай этгээд уг хохирлыг төлж барагдуулна.” гэж заасныг зөрчин цалингийн сангаас 724.5 мянган төгрөгийн зориулалт бус шагнал олгожээ. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байхыг зөвлөмж болгов.

Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1-д “Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно.”, 53.1-д “Илүү цагаар болон долоо хоногийн амралтын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүнд 1.5 дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлсэн цалин хөлс олгоно.” гэж заасан байна.

Дээрх заалтыг зөрчин Хүүхдийн цэцэрлэгийн сахиулаар ажиллаж байсан Наянбаатарт 2014 оны 6,7-р сарын илүү цагийн хөлс 101.2 мянга, 3 өдрийн цалин 53.0 мянга, нийт 154.2 мянган төгрөгийн цалин дутуу олгосон байсанд төлбөрийн акт тогтоолоо.

Цэцэрлэгийн эрхлэгч Н.Нарангэрэл 2014 оны 1,2,3-р сард өвчтэй байсан хугацааг ажилласнаар бүртгэж 291.8 мянган төгрөгийн цалин илүү олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1-д “Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно.” гэж заасныг зөрчсөн тул төлбөрийн акт тогтоолоо.

Хөдөлмөрийн тухай хуулийн 50.2-д “Ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил, албан тушаал хавсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил, үүргийг гүйцэтгэсэн, шөнийн болон илүү цагаар ажилласан бол *үндсэн цалингаас нь* тооцон нэмэгдэл хөлс олгоно” гэж заасныг зөрчин Цэцэрлэгийн нярав Г.Мэндбаярт 2014, 2015 онд ажил хавсран ажилласны нэмэгдэл олгохдоо хавсран ажиллаж байгаа албан тушаалын үндсэн цалингаас тооцохгүйгээр эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингаас тооцож 366.7 мянган төгрөг илүү олгосныг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

Дунд сургууль 2015 онд түлшний мод бэлтгэхэд 5.5 тн буюу 10395.3 мянган төгрөгийн шатах тослох материал зарцуулснаар анхан шатны баримт бүрдүүлсэн байна. Баримтыг тулган баталгаажуулахад 1.9 тн буюу 3513.7 мянган төгрөгийн шатах тослох материалын зардалд хуурамч замын хуудас хөтөлж илүү зарцуулсныг тодруулахад мод бэлтгэхэд ажилласан хүмүүсийн хоолны зардал, цахилгаан хөрөө 3ш, сургуулийн засварын материал, багаж тоног төхөөрөмж ачиж ирсэн тээвэр шатахууны зардал, өөрийн хөрөнгө оруулалтаар сургуульд засвар, тохижилтын ажил хийсэн хүмүүсийн байр, хоолны зардалд зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрсэнд давтан гаргахгүй ажиллахыг зөвлөмж болгож, 3 ш цахилгаан хөрөөг орлогод авах албан шаардлага өглөө.

Цэцэрлэг 2014, 2015 онд түлшний мод бэлтгэхэд 4.5 тн буюу 7489.3 мянган төгрөгийн шатах тослох материал зарцуулснаар анхан шатны баримт бүрдүүлсэн байна. Дээрх баримтыг тулган баталгаажуулахад 2163.6 мянган төгрөгийн шатах тослох материалд хуурамч замын хуудас хөтөлж илүү зарцуулсан байсныг тодруулахад уурын зуухны эргэлтийн усны насос, мод бэлтгэх хөрөөний сэлбэг хэрэгсэл, бензин масло, хоолны агуулах барих банз зүсүүлсний хөлс, цахилгааны төлбөр зэрэг баримт бүрдүүлэн зориулалт бусаар зарцуулсан, 2014 оны 2,3,4-р саруудад хүүхдийн ирцийг хөндий өсгөж 795.8 мянган төгрөгийн хоолны материалыг илүү зарлагадсан зэрэг зөрчлүүд илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д “анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 5.1.2-т “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх;” 6.3.2-т “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах;” 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;” 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг зөрчсөн тул зөвлөмж, хариуцлага тооцуулахаар албан шаардлага өглөө.

Цэцэрлэг 2014 онд 223.2 мянга, 2015 онд 135.3 мянга, нийт 358.6 мянган төгрөг, Дунд сургууль 2014, 2015 онд 1818.8 мянга, Соёлын төв 2014, 2015 онд 141.2 мянган төгрөгийн амралын цалин тус тус илүү тооцож олгосон байгаа тул Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар баталсан ээлжийн амралт бодох заавар, журмыг мөрдөж ажиллахыг зөвлөмж болгов.

1.2. Хууль, тогтоомжийн дагуу батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Цагаанхайрхан сумын төсөвт байгууллагуудын батлагдсан төсөв, гүйцэтгэл дараах байдалтай байна. Үүнд:

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	2014 он			2015 он	
		Гүйцэтгэл	хэтрэлт, хэмнэлт	төлөвлөгөө	Гүйцэтгэл	хэтрэлт, хэмнэлт
ИТХурал	50,866.0	50,866.0	0.0	44,039.1	38,877.8	5,161.3
ЗДТГазар	530,911.6	530,511.6	399.9	359,578.9	349,000.7	10,578.1
ЭМТөв	341,955.9	339,511.8	2,444.1	288,959.4	282,631.7	6327.7
Дунд сургууль	617,046.2	616,302.8	743.4	575,115.8	567,696.8	7,418.9
Хүүхдийн Цэцэрлэг	181,331.1	180,045.7	1,285.4	175,636.7	175,367.9	268.8
Соёлын төв	60,951.3	59,315.9	1,635.4	49,561.8	47,195.3	2,366.5
Бүгд дүн	1,783,062.1	1,776,553.6	6,508.2	1,492,891.7	1,460,770.2	32,121.3

2014 онд батлагдсан төсөвт зардлыг сумын дүнгээр 6508.2 мянган төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан байна. 2015 онд сумын дүнгээр 32121.3 мянган төгрөгөөр төсөвт зардлыг хэмнэлттэй зарцуулснаар тайлагнасан ч төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт олгогдоогүйгээс оны эцэст 45194.7 мянган төгрөгийн өглөгтэй гарчээ.

Төсвийн тухай хуулийн 16.5.3.-д “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэж заасны дагуу сумын төсөвт байгууллагууд батлагдсан орон тоогоороо ажиллажээ. Төсөвт байгууллагууд оны эхэнд албан тушаал, ажилтнуудын ажилласан жил, цалингийн сүлжээ, шатлал, үндсэн цалин, нэмэгдлийн хувь хэмжээг тогтоож баталсан тушаал шийдвэр гаргасан байна.

Төсөвт байгууллагуудын бүтэц, орон тоог хүснэгтээр харуулав. Үүнд:

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	2014 он			2015 он	
		Гүйцэтгэл	хэтрэлт, хэмнэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хэтрэлт, хэмнэлт
ИТХурал	2	2	-	2	2	-
ЗДТГазар	15	15	-	16	16	-
ЭМТөв	27	27	-	27	27	-
Ахлах сургууль	51	51	-	51	51	-
Хүүхдийн Цэцэрлэг	16	16	-	16	16	-
Соёлын төв	8	8	-	8	8	-
Бүгд дүн	119	119	-	119	119	-

Цагаанхайрхан суманд 2014 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хулж, Хунт багийн төвүүдийг өндөр хүчдэлийн шугамд холбоход 341.3 сая, юнителийн үүрэн телефоны дахин дамжуулах сүлжээ тавихад 50.0 сая, сумын төвд 0.4 кв-тын шугамд засвар үйлчилгээ хийж гэрэлтүүлэг тавихад 59.7 сая, 2015 онд сумын төвд гүний цэвэр усны худаг гаргахад 49.9 сая, нийт 501.3 сая төгрөгийн томоохон бүтээн байгуулалтын ажлууд хийгджээ.

2014 онд Сургуулийн хүүхдийн дотуур байранд Боловсрол соёл шинжлэх ухааны яамнаас 14.0 сая, физикийн кабинетийн тоног төхөөрөмж 10.0 сая, даралтат хөгжим, ухаалаг самбар 10.0 сая, сандал ширээ шинэчлэх ажилд 6.0 сая, нийт 40.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Хүүхэд суралцах ая тухтай орчин бүрдүүлснээр “Шилдэг сургалтын таатай орчин бүрдүүлэгч” сургууль, аймгийн “Эрүүл мэндийг дэмжигч” байгууллагаар тус тус шалгарсан байна.

2015 онд иргэн, аж ахуйн нэгжийн хандиваар Дунд сургуулийн сагсны гадна талбай 19.0 сая, дотуур байрны номын санд 0.9 сая төгрөгийн ном, жишиг тасаг тохижуулахад 3.0 сая, МУ-ын гавьяат багш Бадамханд сургуулийн номын санд 6.5 сая төгрөгийн ном, нийт 29.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

2014-2015 онд Хүүхдийн цэцэрлэг нь анги бүрийг камержуулж аюулгүй орчин бүрдүүлэх, хэсэгчилсэн засвар хийх, хүүхдийн ор шинэчлэх зэрэг ажлыг хандиваар, дэлгэц, проектор шинээр авахад Орон нутгийн хөгжлийн сангаас 5.0 сая төгрөгөөр зарцуулан хүүхдийн ая тухтай орчин бүрдүүлж ажилласан байна.

Соёлын төв нь 2014 онд ССАЖЯ-наас 7.2 сая, төсөв болон бусад зардлаас 2.5 сая, нийт 9.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажил хийсэн байна.

Мөн сумын Санхүүгийн алба нь аймгийн хэмжээнд 2014 оны ажлаараа тэргүүн байр эзэлсэн байна.

1.3. Анхан шатны зарим баримтын бүрдэл дутуу байна.

Цэцэрлэг 2014 онд 2 удаа 280.0 мянга, 2015 онд 235.6 мянга, Дунд сургууль 2015 онд 3 удаа 944.3 мянган төгрөгийн гүйлгээг анхан шатны үндсэн баримтгүй хийснийг тодруулж аудитын явцад баримтын бүрдлийг хангуулав.

Хүүхдийн цэцэрлэг нормын хувцас, зөөлөн эдлэл, угаалгын хэрэгслийг шаардах хуудсаар олгохгүй байгаа тул Санхүү, эдийн засгийн сайдын 2002 оны 171/111 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 3.6 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөлөө.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д “анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасан байна.

Гэтэл Хүүхдийн цэцэрлэгийн 2014 оны 2,3,4-р сарын жижүүрийн ирцийн бүртгэл, багш нарын ирцийн бүртгэл, тогоочид өгсөн хоолны материалын баримтыг тулган үзэхэд 795.8 мянган төгрөгийн хоолны материал илүү зарлагдсаныг холбогдох эздээр нь төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч 2013 оны 10-р сард өөрийн дүү Нарангаравын компани руу 1350.0 мянган төгрөгийг шилжүүлж зөөлөн эдлэл

авсан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12.1-д “Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно” гэж заасныг зөрчиж байгааг цаашид давтан гаргахгүй ажиллахыг зөвлөв.

Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын 3.5.7-д “Баримт бичгийн төсөлд санал, виз авч эцэслэн боловсруулсны дараа удирдлагаар хянуулж, батлуулах бөгөөд бичиг хэрэгт бүртгүүлсний дараа холбогдох газарт явуулж, үлдэх хувийг хөтлөх хэрэгт оруулж, хадгална” гэж заасан байна.

Гэтэл Сургуулийн захирал, Цэцэрлэгийн эрхлэгч, Эрүүл мэндийн төвийн дарга нарт үр дүнгийн урамшуулал олгох 2014 оны А/42, А/17, А/100, 2015 оны А/12, А/54, Б/01, А/13, А/103 дугаар захирамж Сумын Засаг дарга гаргасан боловч үндсэн хувь нь сумын Засаг даргын тамгын газрын архивын нэгжид архивлагдаагүй байна. Цаашид архивын баримт бичгийг хууль, тогтоомжийн дагуу бүрдүүлж, эмх цэгцтэй байдлыг хангаж ажиллахыг зөвлөлөө.

Сумын ЗДТГ, Эрүүл мэндийн төв авто машины бензин шатахууныг сумын шатахуун түгээх станцаас зөвшөөрлийн бичгээр буюу зээлээр авч сарын эцэст тооцоо хийж төлбөрийг гүйцэтгэж байна. Жолоочийн замын хуудсыг хөтөлж, тооцоог сар бүр Монгол улсын Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 тоот тушаалаар батлагдсан **“Авто машины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”**-ыг мөрдөж бүсийн болон хүйтний нэмэгдлийг оруулан тооцож бодсон боловч гадны машинд бензин, шатахуун олгохдоо норм хэмжээг тооцоогүй байна.

Төсөвт байгууллагууд шатах, тослох материалыг олгохдоо жагсаалт үйлдээгүйгээс шатахуун олгох зөвшөөрлийн жижиг тасалбар үрэгдвэл хэн ямар ажилд хэдэн литр шатахуун авсан нь тодорхойгүй болох эрсдэл ажиглагдаж байна. Байгууллагын нярвууд бензин шатахууныг хэнд, хэдэн литрийг ямар зориулалтаар олгосон тухай жагсаалт үйлдэж шатахуун хүлээн авсан хүнээр гарын үсэг зуруулж тайланд хавсаргаж байхыг зөвлөлөө.

Эрүүл мэндийн төвийн 2015 оны 10 сарын 19-өөс 12-р сарын 10-ны хооронд өвчтөн аймгийн төв рүү тээвэрлэсэн, сургалтанд оролцсон ч томилолт аваагүй 6 удаагийн шатах тослох материал олгосон замын хуудсыг түүвэрлэн сургалтын удирдамж, шатлалын эмнэлэг рүү шилжүүлсэн бүртгэл зэргийг тулгаж үзэхэд зөрчилгүй байлаа. Томилолтын хуудсанд сургалтын удирдамж, шатлалын эмнэлэгт илгээсэн өвчтөний түүх, судалгааг хөтлөхийг зөвлөлөө.

Бүлэг: 2

Үндсэн хөрөнгө, бараа материалын ашиглалт, хадгалалт хэвийн, тендер зарлахгүйгээр шууд худалдан авалт хийжээ.

2.1. Бараа, ажил үйлчилгээг худалдан авахдаа тендер зарлахгүйгээр шууд худалдан авалт хийжээ.

Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийг батлахдаа барааны хувьд шууд худалдан авах төсөвт өртгийн дээд хязгаарыг 10.0 сая төгрөг байхаар заасан байна.

Цагаанхайрхан сумын зарим төсөвт байгууллагууд 2014, 2015 оны түлш халаалт, шатах тослох материал, хоолны батлагдсан төсвийн хүрээнд тендер зарлаж, гэрээ байгуулахгүйгээр шууд худалдан хийжээ. Иймд цаашид дээрх зардлуудад Засгийн 2013 оны 68 дугаар тогтоолыг хэрэгжүүлж худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг зөвлөмж болгов.

Төсөвт байгууллагуудын шууд худалдан авалт хийсэн зардлуудыг харуулав.

				/мян.төг/
Он	Төсөвт байгууллагын нэр	Түлш халаалт	Тээвэр шатахуун	Хоол
2014	Засаг даргын тамгын газар		14916.1	-
	Хүн эмнэлэг		16763.2	
	Дунд сургууль	20959.0		27266.3
	Цэцэрлэг			28985.6
2015	Засаг даргын тамгын газар	11697.4	13873.7	-
	Хүн эмнэлэг	13626.8	11790.8	
	Дунд сургууль	20959.0		31425.0
	Цэцэрлэг			24717.1



2014 онд сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр цас арилгах, зам арчилгааны зориулалтаар ашиглах трактор авахаар аймгийн Худалдан авах ажиллагааны албанд тендерийн зар хүргүүлжээ. Тендерийг 6-р сард зохион байгуулж Улаанбаатар хотын “Хулан системс” ХХК авч аймгийн Засаг дарга, сумын Засаг даргын гурвалсан гэрээ байгуулж ОХУ-ын ТД “ДОРМАШ” ФОТОН FT - 824 маркийн 90.8 сая төгрөгийн өртөгтэй трактор нийлүүлжээ. Тус трактор нь ашиглалтын явцад техникийн үзүүлэлт, хүчин чадал нь төдийлөн хангалтгүй байна.

Аймгийн засаг даргын 2013 оны А/674 дугаар захирамжаар баталсан “Сумын эмийн эргэлтийн сангийн ажиллах журмыг” зөрчиж Эрүүл мэндийн төвийн автомашины урсгал засварт 500.0 мянга төгрөгийн зардал гаргасан байна. Цаашид эмийн эргэлтийн сангийн журмыг мөрдөж ажиллахыг зөвлөмж өгөв.

2.2. Үндсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт хэвийн байгаа боловч зарим хөрөнгө ашиглалтгүй байна.

Хөрөнгө оруулалтаар Цагаанхайрхан сумын төсөвт байгууллагууд 2014 онд 431304.7 мянга, 2015 онд 452149.1 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнийг данс бүртгэлд тусгасан байна.

Сумын төсөвт байгууллагуудад бараа материал, хөрөнгийн хэсэгчилсэн тооллого хийхэд нийт 28 нэр төрлийн 7595.5 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байсан зөрчлийг арилгуулахаар албан шаардлага өглөө. Үүнд:

- ЗДТГ-ын 8 нэр төрлийн 1199.5 мянган төгрөгийн хөрөнгө
- Цэцэрлэгт 11 төрлийн 5646.0 мянган төгрөгийн хөрөнгө
- Дунд сургуулийн 6 нэр төрлийн хөрөнгө, цахилгаан хөрөө 3 ш 750.0 мянган төгрөг

2.3. Ашиглалтгүй байгаа үндсэн хөрөнгийг шийдвэрлүүлэхээр холбогдох газарт хандсан байна.

ЗДТГ-ын авто тээврийн хэрэгслийн ангилалд бүртгэлтэй УАЗ-469 маркийн автомашин 2ш, мотоцикл 2ш, барилга байгууламжид бүртгэлтэй хуучин наадмын талбай, конторын хашаа, нийт 22740.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр аймгийн Орон нутгийн өмчийн албанд холбогдох баримтыг хүргүүлсэн боловч хариу ирүүлээгүй байна.

Эрүүл мэндийн төв 2014 онд сумын ИТХ-ын шийдвэрээр 15 нэр төрлийн 7342.7 мянга, сумын ЗДТГ 2014 онд 300.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Бүлэг: 3

Дотоод хяналт тогтолцоо бүрдсэн ч зарим байгууллагын өмч хамгаалах зөвлөл хангалтгүй ажилласан байна.

3.1. Дотоод хяналтын тогтолцоо бүрдсэн ч зарим байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл хангалтгүй ажилласан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.4-д “Энэ зүйлийн 3 дахь хэсгийн 1-д заасан өмч хамгаалах Байнгын зөвлөлийг үндсэн үйлдвэрлэл хариуцсан дэд захирал, эсхүл түүний үүрэг биелүүлдэг менежерээр толгойлуулж ерөнхий ня-бо, технологич зэрэг мэргэжлийн ажилтнуудын бүрэлдэхүүнтэйгээр захирлын шийдвэрээр байгуулна” гэж заасан байна.

Сумын төсөвт байгууллагууд төсвийн менежерийн тушаалаар өмч хамгаалах байнгын зөвлөлийг томилон ажиллуулж байна. ЗДТГ, Дунд сургууль, Хүүхдийн цэцэрлэгийн өмч хамгаалах байнгын зөвлөл нь хяналт тавьж ажиллаагүй байна.

Цаашид өмч хамгаалах зөвлөл нь хуулинд заагдсан эрх үүргээ хэрэгжүүлж ажиллахыг зөвлөмж болгов.

3.2. Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн үү.

Цагаанхайрхан суманд 2012-2013 онд хийсэн аудитаар нийт 7 акт тогтоосон байна. Биелэлтийг хүснэгтээр харуулав.

/мян.төгрөг/					
Д/д	Аудитын нэр	Акт, Албан шаардлагын тоо	Актын дүн	Албан шаардлага	Биелэлт
1	ЗДТГ-т	1 акт	49.0		Биелсэн
2	ЗДТГ-т	1 акт	42.0		Биелсэн
3	Дунд сургуульд	1 акт	393.1		Биелсэн
4	Дунд сургуульд	1 акт	94.8		Биелсэн
5	ИТХ-д	1 акт	21.0		Биелсэн
6	ЗДТГ-т	1 акт	392.0		Биелсэн
7	Цэцэрлэгт	1 акт	2529.6		Биелсэн
	ДҮН	7 акт	3521.5		

3.3. “Шилэн дансны ” тухай хуулийг хэрэгжүүлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 5.7-д “Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг энэ хуулийн 5.1-д заасан цахим

хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна” гэж заажээ.

Сумын төсөвт байгууллагууд дээрх заалтын дагуу төсвийн мэдээ тайлангаа болон бусад мэдээллийг байгууллагын самбарт тухай бүр байршуулсан байна.

Нийцлийн аудитаар 1608.5 мянган төгрөгийн төлбөрийн 4 акт тогтоож, 8095.5 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 6 зөвлөмж өглөө.

Холбогдох байгууллагын санал


УВС АЙМАГ
ЦАГААНХАЙРХАН СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
213418, Цагаанхайрхан сум, Мөнхөөхөө
2016.10.28 № 29
танай _____-ны № _____-т

УВС АЙМАГ АУДИТЫН ГАЗАР

Тус суманд хийгдсэн нийцлийн аудитын дүгнэлттэй санал нэг байна. Тайлантай холбоотой ямар нэгэн санал гомдол байхгүй бөгөөд акт, албан шаардлага зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

ДАРГА  Д.ДАГВАСҮРЭН

My doc A-5 alban bicnig

УВААГ-2016/08-НА

Холбогдох байгууллагын ирүүлсэн саналд өгөх тайлбар

Цагаанхайрхан сумын Засаг даргын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 29 дугаартай албан тоотоор аудитын тайланд ирүүлсэн саналд тайлбар өгөх шаардлагагүй гэж үзлээ.

Дүгнэлт

Энэхүү нийцлийн аудитын явцад олж цуглуулсан нотлох зүйлс, баримт материал, судалгаа шинжилгээнд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна.Үүнд:

1. Сумын төсөвт байгууллагууд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендер зарлахгүйгээр шууд худалдан авалт хийжээ.
2. Хууль эрхзүйн актууд нь баримт бичгийн стандарт, архивын нэгжийн шаардлага хангахгүй байна.
3. ЗДТГ, Дунд суургууль, Хүүхдийн цэцэрлэгийн хөрөнгийн ашиглалт хамгаалалт хангалтгүй байна.
4. Дунд сургууль, Хүүхдийн цэцэрлэг шатах тослох материалыг зориулалт бусаар зарцуулсан байна.
5. Дунд сургууль, Цэцэрлэг, Соёлын төвийн ээлжийн амралт тооцох заавар, журмыг мөрдөөгүй байна.
6. Эмийн эргэлтийн сангийн журам зөрчиж зориулалт бус зардал гаргасан байна.

Зөвлөмж

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дор дурьдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна. Үүнд:

Цагаанхайрхан сумын Засаг дарга Д.Дагвасүрэн, төсөвт байгууллагуудын дарга, захирал, эрхлэгч нарт:

1. Сумын төсөвт байгууллагууд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендер зарлаж, гэрээ байгуулан бараа материалыг бэлтгэх.
2. Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, Архивын тухай хуулийг мөрдөж хэрэгжүүлж ажиллаж.
3. Сумын ЗДТГ, Дунд сургууль, Хүүхдийн цэцэрлэгийн хөрөнгийн ашиглалт хамгаалалтанд бүртгэлээр тавих дотоодын хяналтыг сайжуулж, Өмч хамгаалах байнгын зөвлөлийг хуулийн дагуу ажиллуулах.
4. Төсөвт байгууллагууд батлагдсан төсөвт зардлыг зориулалт бусаар зарцуулахыг таслан зогсоож зөрчлийг давтан гаргахгүй байх.
5. Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар баталсан ээлжийн амралт бодох заавар, журмыг мөрдөж ажиллах.
6. Аймгийн засаг даргын 2013 оны 10-р сарын 23-ны А/674 дугаар захирамжаар батлагдсан “Сумын эмийн эргэлтийн сангийн ажиллах журам”-ыг мөрдөж ажиллах.

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ ШИНЖЭЭЧ

М.БАТСУУРЬ

ШИНЖЭЭЧ

Я.ЗУНГАРАВ